

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ. СОНГОХ ДААЛГАВАР

Санамж:

1. Асуулт даалгавар бүрийг анхааралтай, дуустал уншиж гүйцэтгээрэй.
2. Сонгох даалгавраас зөвхөн нэгийг сонгоорой.

1. Аль нь хуучин чулуун зэвсгийн доод үе вэ? /1 оноо/
 A. 800 000-100 000 жилийн үед B. 100 000-40 000 жилийн үед C. 40 000-15 000 жилийн үед
 D. 15 000-8000 жилийн үед E. 8000-3000 жилийн үед
2. Чулуун зэвсгийн мезолитын үеийг Монголын түүх судлалд монголоор юу гэж нэрлэж заншсан бэ? /1 оноо/
 A. Хуучин чулуун зэвсэг B. Дунд чулуун зэвсэг C. Шинэ чулуун зэвсэг
 D. Хүрэл зэвсэг E. Төмөр зэвсэг
3. Эцгийн эрхт овгийн үндсэн шинжүүдийг дурьдахдаа илүүц зүйл өгүүлсэн байна уу? /1 оноо/
 A. Цусан төрлийн холбоо бүхий хүмүүсийн бүлэг
 B. Ясан төрлийн холбоо бүхий бүлэг хүмүүсийн нэгдэл C. Овгийн ахлагч нь эрэгтэй хүн байна.
 D. Хүүхдүүд нь эцгээрээ овоглоно. E. Энд тийм зүйл өгүүлээгүй байна.
4. Хиргисүүрийн зориулалт нь юу байдаг вэ? /1 оноо/
 A. Оршуулгын B. Тахилга, тайллагын C. Газар орноо баримжаалах, таних тэмдгийн
 D. А ба В хариулт E. В ба С хариулт
5. Монгол орныг дэлхийн хүрэл зэвсгийн үйлдвэрлэлийн нэг томоохон төв гэж үздэгийн гол үндэслэлүүд юу байна вэ? /2 оноо/
 A. Хүрэл зэвсэг, аж ахуй, гоёл чимэглэлийн зүйлс монгол оронд ихээхэн тархмал байдаг.
 B. Хүрлийн үеийн гол дурсгалуудын нэг болох дөрвөлжин булш түгээмэл олддог.
 C. Дэлхийн хэмжээнд 700 орчим буган чулуун хөшөө олдоод байгаагийн 550 орчим нь монгол нутгаас олдсон.
 D. Дээрх бүгд хариулт хамаарна. E. В ба С хариулт хамаарна.
6. Монгол нутагт өөрийн төр улсыг байгуулж явсан Түрэгийн хаант улс задран унах болсон шалтгаануудад үл хамаарах зүйл дор өгүүлсэн байна уу? /2 оноо/
 A. Түрэгийн эрхшээлд байсан аймгуудын тэмцэл
 B. Монгол нутагт ноёрхлоо тогтоохын төлөөх Уйгаруудын тэмцэл
 C. Язгууртан сурвалжтнуудын өөр хоорондын тэмцэл
 D. Хятадын Хан улсын хагалан бутаргах бодлого
 E. Тийм зүйл байхгүй байна.
7. 901 онд Елюй овгийн хэн нь Кидан аймгийн холбооны тэргүүнээр өргөмжлөгдөж улсаа байгуулсан бэ? /1 оноо/
 A. Култегин B. Амбагай C. Моюнчур D. Буман E. Пэйло
8. XI-XII зууны үед Гурван мэргэд аймгийн нутаг нь хаагуур байсан бэ? /1 оноо/
 A. Заг Байдраг, Сэлэнгэ Туул, Элсэн говийн хооронд B. Орхоны адаг, Сэлэнгийн дунд биеэр
 C. Хөлөн Буйр нуураар төвлөрч байв. D. Хэрлэн, Онон, Туул голын сав газраар
 E. Орхон голоос Эрчис мөрөн, Хангайн нуруунаас Алтайн чанад хүрч байв.
9. Чингис хааны алтан ургийн үүслийг хаанаас эхтэй гэж үздэг вэ? /1 оноо/
 A. Дарлиган B. Нирун C. Урианхайд D. Хонгирад E. Элжигэн
10. Эрдэмтэд нийт Монгол аймгуудыг талын ба ойн гэж хуваасан байдаг. Талын нүүдэлчин аймгийг тодорхойлох үндсэн шинж юу вэ? /1 оноо/
 A. Мал аж ахуй голлон эрхлэнэ. B. Малынхаа ашиг шимээр хэрэгцээгээ ханган нүүдэллэн амьдарна.
 C. Цаа буга, сарлаг зэрэг онцлог сүрэгтэй. D. А ба В хариулт зөв.
 E. В ба С хариулт зөв.
11. XIII зууны эхэн үед Монголын өмнөд талд ямар улс оршин байв? /1 оноо/
 A. Сүн улс B. Алтан улс C. Си-Ся буюу Тангуд улс D. Хорезми E. Хятан
12. 1206 онд Их Монгол улс байгуулагджээ. Энэ нь хэддүгээр жаранд болсон бэ? /1 оноо/
 A. 1 дүгээр жаран B. 2 дугаар жаран C. 3 дугаар жаран
 D. 4 дүгээр жаран E. 5 дугаар жаран

13. Их Монгол улсын нутаг дэвсгэрийг баруун, зүүн, төвийн гэсэн гурван их түмэнд хуваасан байжээ. Баруун түмнийг хэн захирч байсан бэ? /1 оноо/
 А. Мухулай В. Шихихутаг С. Боорчи D. Зэлмэ E. Наяа
14. Их Монгол улс, Монголын эзэнт гүрний үед “уртаг” хэмээх нийгмийн бүлэг нь: /1 оноо/
 А. Монголын их хаадаас санхүүгийн дэмжлэг авдаг
 В. Монголын хаадын нэрийн өмнөөс худалдаа хийдэг Дундат Азийн хүмүүс
 С. Хятад худалдаачдыг ийнхүү нэрлэдэг байв.
 D. А ба В хариулт хамаарна. E. В ба С хариулт хамаарна.
15. Дараах үйл явдлыг болсон газар нутагтай нь тохируулна уу? /2 оноо/
 А. Чингис хааны гэрэлт хөшөө 1. Онон мөрний Дэлүүн болдог
 В. Тэмүүжин Хамаг Монголын ханд өргөмжлөгдөв. 2. Хэнтийн Дадал сум
 С. Их Монгол улс байгуулагдсаныг тунхаглан зарлав. 3. Хар зүрхний Хөх нуур
 D. Чингис хаан мэндэлсэн. 4. Онон мөрний эх
 А. А3, В1, С2, D4 В. А4, В2, С1, D3 С. А2, В3, С4, D1
 D. А1, В4, С2, D3 E. А2, В3, С1, D4
16. 1206 онд байгуулагдсан Их Монгол улсын хилийн өрнө тал нь хаагуур хиллэж байсан бэ? /1 оноо/
 А. Байгаль нуур В. Түмэн газрын Цагаан хэрэм С. Хянганы нуруу
 D. Алтайн нурууны чанад E. Хөвсгөлийн уулс
17. Өгөөдэй хааны түүхэнд гүйцэтгэсэн үүргийг дурьдахдаа хамааралгүй зүйл өгүүлсэн байна уу? /1 оноо/
 А. Их Монгол улсын нийслэл Хархорумыг цогцлоон байгуулсан.
 В. Албан татварын хэмжээг боловсронгуй болгож хураах татварыг хэмжээг хуульчилсан.
 С. Уургын улааг халж, морин өртөөг байгуулсан.
 D. Говьд худаг гаргаж бэлчээр нутгийг элбэг болгосон.
 E. Ийм зүйл өгүүлээгүй байна.
18. Дор өгүүлсэн зүйлээс Их Монгол улсыг байгуулах түүхэн шаардлагыг ялгаж нэрлэнэ үү? /2 оноо/.
 А. Зүрчидийн Алтан улсын эсрэг хүчээ нэгтгэх
 В. Аймаг ханлигуудын хооронд аж ахуйн харилцаа холбоо үүссэн
 С. “Урт дурын хүмүүс” хэмээн нэрлэгдсэн бүлэг бий болсон
 D. Хамаг Монголын ханлигийн нэгдэл сэргэсэн
 E. Түүхийн тавцанд Тэмүжин гарч ирсэн.
19. Их Монгол улс байгуулагдсаны түүхэн ач холбогдлын тухай илүүц зүйл өгүүлсэн байна уу? /2 оноо/
 А. Нүүдлийн иргэншлийг уналтанд орсон.
 В. Хэл, шашин, соёлын нийтлэг бий болж Монгол угсаатан бүрэлдсэн.
 С. Монгол ханлиг, аймгуудыг нэгтгэснээр тодорхой нутаг дэвсгэр, хил хязгаар бүрэлдэн тогтсон.
 D. Монгол бичгийг төрийн бичиг болгосноор албан бичгийн хэл бүрэлдэн тогтсон.
 E. Энд тийм зүйл өгүүлээгүй байна.
20. Рашид-ад Дины “Судрын чуулганд буй “Монголчуудын дотроос Отчигин ноён бол барилгын үйл хэрэгт их дуртай, хаа явсан газраа орд хөрш, /Сарай/ хотын захын орд /Кушк/ барьж босгож байсан ба цэцэрлэг мод /баг/ тарьж суулгаж байв” гэсэн мэдээ дорх дүгнэлтүүдийн алины нь үндэслэгээ болох вэ? /2 оноо/
 А. Отчигин Сарай хотын захад орд барьсан.
 В. Отчигин бол барилгын ажлыг ихэд сонирхдог хүн байжээ.
 С. А ба В гаргалгааны үндэслэл болно. D. Зөвхөн В гаргалгааны үндэслэл болно.
 E. Аль ч гаргалгааны үндэслэл болж чадахгүй.
21. 1368 онд Юань гүрэн унаж Хятад дахь Монголын ноёрхол эцэс болжээ. Энэ нь хэддүгээр зууны хэддүгээр хагаст болсон үйл явдал вэ? /1 оноо/
 А. XIII зууны I хагас В. XIII зууны II хагас С. XIV зууны I хагас
 D. XIV зууны II хагас E. XV зууны I хагас
22. Улс төрийн бутралын үеийн баруун Монголын Ойрад түмний бүрэлдэхүүнд багтаж байсан түмнүүдийг нэрлэхдээ буруу зүйл оруулсан бол аль нь вэ? /1 оноо/
 А. Цорос В. Торгууд С. Хошууд D. Дөрвөд E. Цахар

23. Монголд шарын шашныг дэлгэрүүлэхийн тулд авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийг дурьдахдаа буруу ташаа зүйл өгүүлсэн байна уу? /2 оноо/
- A. Улс орны нэгдмэл байдлыг бэхжүүлэх зорилготой шашныг ашиглах
 B. Төрийн зүгээс лам нарын эрх дархыг хуульчлан бэхжүүлэх бодлого явуулсан.
 C. Сүм хийдийг олноор нь байгуулсан.
 D. Лам болохыг хөхүүлэн дэмжиж албан татвараас чөлөөлөх зэргээр дэмжиж байсан
 E. Хойлоглох зан үйлийг дэмжин дэлгэрүүлж байсан.
24. Монголын төрийг хамгийн олон жил барьсан хаан хэн бэ? /1 оноо/
- A. Чингис хаан B. Өгөдэй хаан C. Хубилай хаан D. Тогоонтөмөр E. Батмөнх даян хаан
25. Манжийн эрхшээлийн үеийн Монголын түүхийн хамрах цаг хугацааг нэрлэнэ үү? /1 оноо/
- A. НТӨ 209-НТ XIII зуун B. XIII-XIV зуун C. XIV-XVII зуун
 D. XVII-XX зууны эх E. 1911-1919 он
26. Дор дурьдсан оны цолын аль нь Манжийн үеийн түүхэнд хамаарах вэ? /1 оноо/
- A. Бурхны шашны сургаал ёсоор Ашид амгалан, Машид тайван, Энх түвшин гэх мэт оны цол
 B. Олноо өргөгдсөн гэсэн оны цол C. Монгол улсын гэсэн оны цол
 D. Энх-Амгалан, Найралт төв, Тэнгэрийн тэтгэсэн гэх мэт оны цол
 E. Энд ийм зүйл байхгүй байна.
27. Дор дурьдсан үйл явдлуудыг болсон цаг хугацааны дагуу эрэмбэлнэ үү? /2 оноо/
1. Баруун Монгол Манжид эзлэгдэв.
 2. Өвөр Монгол Манжид эзлэгдэв.
 3. Халх Монгол Манжийн эрхшээлд оров.
 4. Тарвагатайн Улаан бураа хэмээх газар “Монгол-Ойрадын Их цааз” батлагдав.
- A. 3, 1, 2, 4 B. 4, 2, 3, 1 C. 2, 4, 3, 1 D. 1, 2, 3, 4 E. 2, 4, 1, 3
28. Улс төрийн бутралын үед Монголын соёлд гарсан шинэ зүйлүүдийг нэрлэхдээ илүүц зүйл өгүүлсэн байна уу? /2 оноо/
- A. “Мандухай цэцэн хатны домог” “Убаши хунтайжийн тууж” зэрэг зохиолууд гарав
 B. Ном хэвлэх барханы газрууд томоохон сүм хийдийн дэргэд байгуулагдсан
 C. Монголын дүрслэх урлагт цутгуурын урлаг гэдэг төрөл зүйл бий болсон.
 D. Галиг үсэг, тод үсэг, соёмбо үсэг зэрэг шинэ үсэг бичгүүд зохиогдсон
 E. Энд тийм зүйл өгүүлэгдээгүй байна.
29. Дор дурьдсан шинжүүдийн аль нь хамжлага ард гэсэн нийгмийн давхрааг тодорхойлж байна вэ? /1 оноо/
- A. Манжийн захиргааны хэрэгт хүчин зүтгэдэг монголын нийгмийн давхрааны дээд хэсэг
 B. Манжийн төрийн олон зүйлийн хүнд хүчир албанд зүтгэдэг цэрэг эр
 C. Аймаг, хошууныхаа ноёд язгууртнуудын мэдэлд захирагддаг харьяат албат
 D. Хутагт хувилгаад, сүм хийдийн мэдэлд захирагдагсад
 E. Манжийн харуулын алба хаадаг хүмүүс
30. Дараах бичвэрт цэгийн оронд тохирох үгийг нөхөн бичнэ үү? /2 оноо/
- Аюуш гүүш 1587 онд 1. үсэг, 2. 1648 онд Тод үсэг, Өндөр гэгээн Занабазар 1686 онд 3. үсгийг тус тус зохиожээ.
- A. Саган сэцэн B. Зая бандид Намхайжамц C. Дөрвөлжин үсэг
 D. Вагиндрагийн үсэг E. Али гали үсэг F. Соёмбо үсэг
 A. 1a, 2b, 3d, B. 1f, 2d, 3a, C. 1e, 2d, 3c, D. 1e, 2b, 3f, E. 1c, 2a, 3d,

31. Манж Чин улсын үеийн Халхын засаг захиргааны хуваарь

Аймаг	Чуулган	Хошуу	Сум
Түшээт хан	Хан уул	20	52
Сэцэн хан	Барс хот	23	40
Сайн ноён хан	Цэцэрлэг	24	31
Засагт хан	Биндэрьяа нуур	19	20
		86	143

Энэ баримтанд хийсэн гаргалгаанд буруу ташаа зүйл байна уу? /2 оноо/

- A. Халхын дөрвөн аймаг 86 хошуунд хуваагдаж байв.
 B. Хамгийн олон хошуутай нь Сайн ноён хан аймаг
 C. Хамгийн цөөн сумтай нь Засагт хан аймаг байв.
 D. Хамгийн олон сумтай нь Түшээт хан аймаг

Е. Энд тийм зүйл өгүүлээгүй байна.

32. 1755-1758 оны зэвсэгт бослогын дарагдсан шалтгаанд аль нь хамаарахгүй вэ? /2 оноо/
 А. Босогчид дотооддоо эв нэгдлээ сахиж, хүчээ нэгтгэж чадаагүй
 В. Бослогод оролцсон зарим нөлөө бүхий ноёд Манжид урвасан.
 С. Бослогод оролцогчид нэгдмэл нэг санааг тууштай дэмжиж байсан.
 D. Нэгдсэн удирдлага зохион байгуулалтгүй байсан.
 E. Манжийн зэр зэвсэг, цэргийн хүч илүү байсан.
33. “Хөх судар” хэмээх романыг туурвисан бөгөөд Монголын түүх бичлэгт шүүмжлэлт чиглэлийг бий болгосон зохиолч хэн бэ? /1 оноо/
 А. Инжинаш В. Гэлэгбалсан С. Равжаа D. Рашпунцаг E. Ишбалжир
34. Манжийн төрийн шинэ засгийн бодлогын хүрээнд эдийн засгийн салбарт авч хэрэгжүүлсэн бодлого, арга хэмжээнүүдийг ялган нэрлэ. /2 оноо/
 1. Манжийн төр хятадын худалдаа мөнгө хүүлэгч пүүсүүдийг дэмжих
 2. “Монгол үгийн бодрол” сонинг Хятад Монголоор хэвлэн тараав.
 3. ГМТЗЯЯ-ны бүтцэд өөрчлөлт оруулан, “Байцаах товёоо” “Найруулах товчоо”-г байгуулав.
 4. Уурхай байгуулж ашигт малтмал олборлох, байгалийн баялагыг ашиглах, банк байгуулах зэрэг санал дэвшүүлэн хэрэгжүүлж эхлэв.
 5. 1905 онд Их Хүрээнд Цагдан сэргийлэх яамыг байгуулсан.
 6. Зохиомол өрийн данс нээж, өрийг ихэсгэв.
 7. Манж-Хятад хэлний сургуулиуд байгуулав.
 8. Монголын цэрэг, харуулын байршил, тоог тодорхойлон гаргасан.
 9. Монголчуудыг “мэдлэг ухаан бас бурангуй” гэж бичиж байсан.
 А. 1, 3, 5 В. 2, 7, 9 С. 3, 5, 8 D. 1, 4, 6 E. 3, 4, 5
35. Монгол улсын/1911-1919/улсын үед хүн амын нягтралын талаар зарим судлаачдын гаргасан судалгаагаар “нэг хавтгай дөрвөлжин бээрт Сэцэн хан аймагт дунджаар 0,39, Түшээт хан аймагт 0,34, Сайн ноён хан аймагт 0,50, Засагт хан аймагт 0,36, Ховдын хязгаарт 0,29, Хөвсгөл дэх Богд гэгээний эзэмшилд 0,45 хүн амьдарч байсан ба энэ үзүүлэлтийн улсын дундаж нь 0,44 байлаа”. Энэ баримтанд дорх гаргалгааны аль нь хамаарах вэ? /2 оноо/
 А. Сайн ноён хан аймаг, Хөвсгөл дэх Богд гэгээний эзэмшил зэрэг нутгуудад хүн ам харьцангуй нягт суурьшсан буюу улсын дунджаас дээгүүр
 В. Ховдын хязгаар, Засагт хан аймагт харьцангуй сийрэг суурьшсан буюу улсын дунджаас доогуур
 С. Хүн амын нягтралаар хамгийн их нь Ховдын хязгаар Хамгийн сийрэг суурьшилтай нь Сайн ноён хан аймаг байна.
 D. А ба В хариулт хамаарна
 E. В ба С хариулт хамаарна.
36. 1914 оны VIII сард эхэлсэн 3 улсын Хиагтын бага хурал дээр Монгол улсын баримталж байсан байр суурь нь: /2 оноо/
 А. Ар Монголд Хятадын эзэрхийлэлийг ёс төдий тогтоох
 В. Ар, Өвөр монголыг Хятадын харьяаны болгох
 С. Тусгаар тогтнолоо баталгаажуулах, Монгол улсад нэгдэхээ илэрхийлсэн монголчуудаа нэгтгэх
 D. Халх 4 аймаг, Ховдын хязгаараар заагласан Монгол улсыг хүлээн зөвшөөрүүлэх
 E. Ар, болон Өвөр монголыг салангид тусгаар байлгах
37. 1912 онд байгуулагдсан Бүгд Ерөнхийлөн захирах яамны эрх хэмжээг дурьдахдаа илүүц зүйл өгүүлсэн байна уу? /1 оноо/
 А. Улс орныг байнгын төрийн удирдлагаар хангах
 В. Улс төр, нийгэм, эдийн засгийн шинэтгэлийг удирдах
 С. Улс төр, нийгэм, эдийн засгийн шинэтгэлийн хэрэгжилтэнд хяналт тавих
 D. Цол хэргэм зэргээр шагнах
 E. Энд тийм зүйл дурьдаггүй байна.
38. Ард Аюушаар удирдуулсан манжийг эсэргүүцсэн заргын тэмцэл хаана гарсан бэ? /1 оноо/
 А. Ховд В. Их Хүрээ С. Хиагт D. Сан бэйсийн хүрээ E. Улиастай
39. Сурагч Ганбатын аав Жанцан одоогийн Хэнтий аймгийн нутагт төржээ. Энэ нь уламжлалт засаг захиргааны хуваариар аль аймаг вэ? /1 оноо/
 А. Засагт хан аймаг В. Түшээт хан аймаг C. Сайн ноён аймаг

D.Сэцэн хан аймаг

E.Дөрвөд Далай ханы аймаг

40. XX зууны эхэн үед шашны зургийн номлолын журам горимыг эвдэж, амьдралтай холбон бодит байдлаар дүрслэн зурсан “Монголын нэг өдөр” зургийг хэн зурсан бэ? /1 оноо/

A. Дорж

B. Жүгдэр

C. Сономцэрэн

D. Шарав

E. Цэвэгжав

41. Дорхи газрын зурагт Засагт хан аймгийг хэдийн тоогоор дугаарласан байна вэ? /1 оноо/



A. 1

B. 2

C. 3

D. 4

E. 5

42. Цэгийн оронд тохирох өгөгдлийг сонгоно уу? /1 оноо/

1921.VII.10-нд Ардын засгийн газрын ерөнхий сайд бөгөөд Гадаад яамны тэргүүн сайдаарыг томилжээ.

A. Да лам Пунцагдорж

B. Д.Сүхбаатар

C. Д.Бодоо

D. С.Данзан

E. Н.Магсаржав

43. 1921-1924 онуудад улс төрийн салбарт авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийг нэрлэнэ үү. /2 оноо/

1. 1921 оны 11 дүгээр сард Судар бичгийн хүрээлэнг байгуулав.
2. Анхдугаар үндсэн хуулийг баталлаа.
3. 1921 оны 7 дугаар сард гадаадын пүүсүүдэд төлөх улсын ба иргэдийн өрийг хүчингүй болгов.
4. 1921 оны 11 дүгээр сард бага сургууль байгуулагдав.
5. Байнгын засгийн газар байгуулагдав.
6. “Уриа”, “Ардын эрх”, “Ардын цэрэг”, “Ургинская газета”, “Манай үнэн” зэрэг сонин хэвлэгдэн гарав.
7. Ховд, Зүүн Хараад төрийн өмчийн тариалангийн газар-сангийн аж ахуй байгуулав.
8. Улс орноо цагаантны цэргээс чөлөөлөв.
9. Хувийн өмчинд байсан жижиг үйлдвэрүүдийг улсын болгов.

A. 3, 5, 7

B. 1, 2, 3

C. 2, 4, 6

D. 2, 5, 8

E. 7, 8, 9

44. Доор өгүүлсэн зүйлээс аль нь С.Данзангийн үзэл бодол вэ? /2 оноо/

- A. “Хэмжээт эрхт хаант засаг бол хуучнаас шинэ байгуулалд шилжих зайлшгүй байх ёстой засаглалын хэлбэр тул тухайн цаг үед нэг хэсэгтээ тохиромжтой.”
- B. “... Бурхны шашнаа хүндэтгэж ард түмнийг амгалан туйл дор хүргүүлэн тэгш журамт баян хүчирхэг улс болохыг гол болгосон хэрэг болой.”
- C. “Юун хэмээвээс ертөнцийн хүн төрөлхтөн бүгдээр найрамдах буюу зөвлөлдөх мэтсийн олон зэрэг дэс байр байх бөгөөд үлгэрлэвээс авирах гишгүүрт нэгээс үүсгэн дэвших ба усанд гүехнээс гүнд орохоор утга адил буй”
- D. “МАН-ын эцсийн зорилт нь эв хамтын ёс мөн бөгөөд нам капитал хөрөнгөтний хөгжлийн шатыг алсгах зорилгод хүрэхээр урагшаа давшин явж байна.”
- E. Аль нь ч биш.

45. Доор дурьдсан үйл явдлуудаас аль нь зүүнтний үе /1929-1932/ хэмээн нэрлэгддэг үед болсон бэ? /2 оноо/

1. Улсын дээд, доод хурал байгуулагдав.
2. Монгол, ЗОУ-ын хооронд найрамдлын гэрээ байгуулжээ.
3. “Феодал” агчдын хөрөнгийг хураав.
4. “Зарлигаар тогтоосон Монгол улсын хууль зүйлийн бичиг” хууль гарчээ.
5. Хувийн худалдааг хориглохоо больж, худалдаачдад тусламж дэмжлэг үзүүлэв.
6. Жасын кампни гэж нэрлэгдсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэв.
7. Богд хаан ба Засгийн газрын хооронд “Тангарагийн гэрээ” байгуулав.
8. Олноор байгуулсан хамтрал, коммуныг татан буулгав.

- A. 1,4 B. 2,7 C. 3,6 D. 5,8 E. 3,7
46. “Феодал” агчдын хөрөнгийг хураах кампанит ажлын явцад 1560 гаруй өрхийн хөрөнгийг хураажээ. Нэг өрхөд 100 “хувь”-ийн хөрөнгө үлдээсэн бол малын үнээр тооцвол нийт хичнээн төгрөгийн хөрөнгөө хураалгасан өрхүүдэд үлдээсэн бэ? /2 оноо/
 A. 2,8 сая орчим төгрөгийн B. 3,5 сая орчим төгрөгийн C. 4,7 сая орчим төгрөгийн
 D. 5,7 сая орчим төгрөгийн E. 6 сая орчим төгрөгийн
47. Монголын 1921 оны хувьсгалын удирдагчдын нэг Х.Чойбалсангийн үйл ажиллагаа түүхэнд гүйцэтгэсэн үүргийн талаар илүүц зүйл дор өгүүлсэн байна уу? /2 оноо/
 A. 1921 оны 3 сараас АТЗГ-ын гишүүн суртлыг номлогч Бүх цэргийн дэд жанжны алба хашиж байсан.
 B. БНМАУ-ын 8-р УИХ-аас СнЗ-ийн ерөнхий сайдаар томилогдож насан эцэс болтлоо ажилласан.
 C. 1929-1932 онуудад “феодал” агчдын хөрөнгө хураах комиссыг толгойлж байсан.
 D. 1956 онд гарсан “Сэхээтний төөрөгдөл” хэмээх үйл ажиллагааг зохион байгуулсан.
 E. Энд тийм зүйл өгүүлээгүй байна.
48. Улс төрийн хэлмэгдүүлэлтийн “оргил үе” хэдийд тохиосон бэ? /1 оноо/
 A. 1922-1928 он B. 1928-1932 он C. 1932-1937 он
 D. 1937-1939 он E. 1939-1956 он
49. Манай улсын аль үндсэн хуулинд анх удаа “МАХН бол улс нийгмийн бүх байгууллагуудыг удирдах гол хүчин” гэж хуульчлан заасан бэ? /1 оноо/
 A. 1924 оны үндсэн хуулинд B. 1940 оны үндсэн хуулинд C. 1960 оны үндсэн хуулинд
 D. 1992 оны үндсэн хуулинд E. Аль ч үндсэн хуулинд ийм заалт байхгүй.
50. 1945 оны 2 дугаар сард Ялтын бага хурал дээр ЗХУ, Их Британи, АНУ-ын удирдагчид Ар Монголын статус квот хүлээн зөвшөөрчээ. Ялт нь ямар улсын нутаг вэ? /1 оноо/
 A. ЗХУ B. Их Британи C. АНУ D. Монгол E. Хятад
51. XX зууны монголын урлаг, шинжлэх ухааны зүтгэлтнүүдийн нэрсийг бичсэн дөрөвдүгээр мөрийг ямар шалгуурыг баримтлан үүсгэсэн байна вэ? /1 оноо/
 1. Д.Пүрэвдорж, Р.Чойном, С.Удвал, Б.Явуухулан
 2. Ц.Дамдинсүрэн, Б.Ринчин, Ш.Нацагдорж, Б.Ширэндэв
 3. Б.Дамдинсүрэн, Р.Мөрдорж, Д.Лувсаншарав, Г.Бирваа
 4. О.Цэвэгжав, Г.Одон, Н.Цүлтэм, Л.Гаваа
 5. Ж.Жигжид, Б.Сумхүү, Ж.Бунтар, Г.Жигжидсүрэн
 A. Кино урлагийн салбарын төлөөлөл B. Монголын уран зургийн салбарын төлөөлөгчид
 C. Монголын зохиолчдын төлөөлөл D. Монголын хөгжмийн зохиолчдын төлөөлөл
 E. Монголын шинжлэх ухааны эрдэмтдийн төлөөлөл
52. 1961 онд БНМАУ НҮБ-д гишүүнээр элссэний түүхэн ач холбогдлыг өгүүлэхдээ үл хамаарах зүйл дурьдсан байна уу? /2 оноо/
 A. БНМАУ-ын олон улсын нэр хүнд өссөн.
 B. Бусад орнууд ялангуяа өрнөдийн орнууд манай улстай дипломат харилцаа тогтоох боломж нээгдсэн.
 C. Манай улс НҮБ-ийн хүрээнд идэвхтэй гадаад бодлого явуулах боломж өргөжсөн.
 D. Манай улсын ЗХУ болон БНХАУ-тай харилцах харилцаа муудахад хүргэсэн.
 E. Энд тийм зүйл өгүүлээгүй байна.
53. Монгол улсын ерөнхийлөгч нарын уг албан тушаалд ажиллаж байсан болон ажиллаж байгаа он цагийг зөв тохируулна уу? /2 оноо/
 A. Пунсалмаагийн Очирбат 1. 2009 оноос
 B. Нацагийн Багабанди 2. 2005-2009 он
 C. Намбарын Энхбаяр 3. 1997-2005 он
 D. Цахиагийн Элбэгдорж 4. 1990-1997 он
 A. a1, b2, c3, d4 B. a2, b4, c1, d3 C. a4, b3, c2, d1
 D. a4, b3, c1, d2 E. a3, b1, c3, d4
54. Өнөөгийн Монгол улсын гадаад бодлогын гурав дахь чиглэл юу вэ? /2 оноо/
 A. АНУ, Япон, ХБНГУ зэрэг өндөр хөгжилтэй орнуудтай найрсаг харилцаа тогтоох
 B. Хуучин социалист гэгдэж байсан дорнод Европын орнуудтай харилцаагаа сэргээх
 C. Уламжлалт харилцаатай хоёр их хөрш ОХУ, БНХАУ-тай найрсаг харилцаатай байх
 D. Азийн бүс нутагт байр сууриа бататган энэ бүс нутгийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцох
 E. НҮБ, түүний төрөлжсөн байгууллагуудтай хамтран ажиллах

55. Доорх төрийн сүлд аль үед хүчин төгөлдөр байсан бэ?

/1 оноо/



- A. 1911-1919 оны үед
- B. 1919-1940 оны үед
- C. 1940-1960 оны үед
- D. 1960-1992 оны үед
- E. 1992 оноос

56. Өөрчлөлт шинэчлэлийн жилүүдэд гадаад харилцаанд авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийг нэрлэнэ үү?.

/2 оноо/

1. 2005 онд АНУ-ын ерөнхийлөгч Жорж Буш Монголд айчлав.
2. Улс төрийн намуудын тухай хууль батлагдан, олон намын систем тогтов.
3. Монгол улс эвсэлд үл нэгдэх хөдөлгөөнд 103 дахь орон болж элсжээ..
4. НҮБ-ын 47 дугаар чуулган дээр Монгол улс өөрийн нутгийг цөмийн зэвсэггүй бүс хэмээн зарлав.
5. 2010 оны байдлаар манай орон дэлхийн 140 гаруй оронтой дипломат харилцаа тогтоосон байв.
6. Монгол бичгээ сэргээх, хос бичигтэн болох ажил өрнөж байна.

- A. 1, 2, 3 B. 3, 4, 6 C. 5, 6 D. 1, 3, 4 E. 4, 5

ХОЁРДУГААР ХЭСЭГ. ХАРГАЛЗУУЛАХ, ДАРААЛАЛ СЭРГЭЭХ ДААЛГАВАР

Санамж:

1. Даалгаврыг хариуг зөв тогтоож харгалзуулах дараалал сэргээх байдлаар гүйцэтгэнэ үү.
2. Зөв хариулт бүр 1 оноотой

2.1 Монголын түүхийн дурсгалууд олдсон газрыг одоогийн аймаг нутгаар нь тохируулан нэрлэнэ үү? /5 оноо/

- A. Норовлингийн суурин
- B. Хойд Цэнхэрийн агуй
- C. Можоогийн хад
- D. Рашаан хад
- E. Цагаан агуй



2.2 1920-иод онд аймгуудын нэрийг өөрчилж уул усны нэрээр нэрлэх болжээ. Аймгуудын уламжлалт болон шинэ нэрийг оноон тохируулна уу? /5 оноо/

- A. Засагт хан
 - B. Түшээт хан
 - C. Сайн ноён хан
 - D. Сэцэн хан
 - E. Ховдын хязгаар
- 1. Хан Хэнтий уулын аймаг
 - 2. Чандмань уулын аймаг
 - 3. Хантайшир уулын аймаг
 - 4. Богд хан уулын аймаг
 - 5. Цэцэрлэг мандал уулын аймаг

2.3 XX зуунд манай улсыг нэрлэж байсан нэрийг он цагийн дарааллаар нь /эхнээс нь эхлэн 1-5 гэж дугаарлана/ эрэмбэлнэ үү? /5 оноо/

- A. БНМАУ
- B. Автономит Монгол улс
- C. Монгол улс
- D. Хэмжээт цаазат Монгол улс
- E. Олноо өргөгдсөн Монгол улс

2.4 Цэгийн оронд тохирох утгыг нөхөж бичнэ үү?

/5 оноо/

Монгол улсын гадаад бодлогын хүрээний шинэчлэлд А. боловсруулсан, 2004 оны эцсээр В. –д төлөх өрийг тус улсад ашигтайгаар шийдвэрлэв. 1987 онд С. тай дипломат харилцаа тогтоов. Манай улсын гадаад худалдааны гол түнш нь D. болж, 1980-аад оны дунд үеэс E. тай тогтоосон харилцаа холбоо өргөжин гүнзгийрч байна.

1. Япон
2. Гадаад бодлогын үзэл баримтлал
3. БНХАУ
4. ОХУ
5. АНУ

